УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ФОРВАРД ГЭРЭЭНИЙ АРИЛЖААНЫ ЗАР

<table>
<tr><td>1</td><td>Худалдагч этгээдийн нэр</td><td>“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ</td></tr>
<tr><td>2</td><td>Арилжаа зохион байгуулагдах огноо, цаг</td><td>2026-11-20
14:00</td></tr>
<tr><td>3</td><td>Уул уурхайн бүтээгдэхүүний төрөл, ангилал</td><td>22.35%-ийн зэсийн агуулгатай баяжмал, ангиллын код: 2603.00.20</td></tr>
<tr><td>4</td><td>Чанарын үзүүлэлт</td><td><table><tr><th>Хэмжигдэхүүн</th><th>Чанарын үзүүлэлт</th></tr><tr><td>Зэс /Cu/</td><td>22.35%</td></tr><tr><td>Мөнгө /Ag/</td><td>78 гр/тн</td></tr><tr><td>Хүнцэл /As/</td><td><0.3%</td></tr><tr><td>Чийглэг /moisture/</td><td>9.4%</td></tr><tr><td>Молибден /Mo/</td><td><0.15%</td></tr><tr><td>Төмөр /Fe/</td><td><30%</td></tr><tr><td>Цайр /Zn/</td><td><0.7%</td></tr><tr><td>Хар тугалга /Pb/</td><td><1.4%</td></tr><tr><td>Хүхэр /S/</td><td><37%</td></tr><tr><td>Алт /Au/</td><td><0.3 гр/тн</td></tr><tr><td>Хөнгөн цагаан /Al/</td><td><2.0%</td></tr></table></td></tr>
<tr><td>5</td><td>Багцын тоо, нийт хэмжээ</td><td>80,000 НМТ /нойтон метр тонн/
72,480 ХМТ /хуурай метр тонн/</td></tr>
<tr><td>6</td><td>Дуудах доод үнэ, валютын төрөл</td><td>3,272.16 ам.дол/ХМТ</td></tr>
<tr><td>7</td><td>Тогтмол үнэтэй, индексэд суурилсан эсхүл хөвөгч үнэтэй захиалга эсэх</td><td>Хөвөгч</td></tr>
<tr><td>8</td><td>Чанарын зөрүүнд тооцох үнийн нэмэгдэл, бууралт байгаа эсэх, тооцох аргачлал</td><td>Монголын Хөрөнгийн биржид бүртгэгдсэн, Лондонгийн Металлын Биржийн гишүүнчлэлтэй, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хөндлөнгийн хяналтын байгууллага Худалдагчийн агуулахад баяжмал ачигдах үед лот тус бүрээс химийн агуулга тодорхойлох дээжийг олон улсын стандартын дагуу бэлтгэж, химийн шинжилгээг хийнэ. Хөндлөнгийн хяналтын байгууллагын тодорхойлсон энэхүү шинжилгээний үр дүнг хоёр тал хүлээн зөвшөөрч эцсийн тооцоонд хэрэглэнэ.</td></tr>
<tr><td>9</td><td>Дуудах үед үнэ өсгөх хамгийн бага дүн</td><td>5 ам.доллар</td></tr>
<tr><td>10</td><td>Гэрээ дуусгавар болох хугацаа</td><td>2027 оны 8 дугаар сарын 31</td></tr>
<tr><td>11</td><td>Хүргэлт хийх хугацаа, нөхцөл /хэсэгчилж хүргэлт хийх тохиолдолд хүргэлтийн хуваарь/</td><td>Нийлүүлэлтийг дараах хуваарийн дагуу хийнэ
2027 оны 2-р сар 16,000 НМТ
2027 оны 3-р сар 16,000 НМТ
2027 оны 4-р сар 16,000 НМТ
2027 оны 5-р сар 16,000 НМТ
2027 оны 6-р сар 16,000 НМТ
DAP (Инкотермс 2020, түүнд орсон нэмэлт өөрчлөлт)
Монгол-Хятадын хил (Эрээн)</td></tr>
<tr><td>12</td><td>Бүтээгдэхүүн нийлүүлэх цэг</td><td>БНХАУ-ын Эрээн өртөө, зэсийн баяжмал ачих, буулгах талбай</td></tr>
<tr><td>13</td><td>Тээвэрлэлтийн төрөл</td><td>Төмөр зам</td></tr>
<tr><td>14</td><td>Дэнчингийн хэмжээ</td><td>10% буюу 23,716,615.68 ам.дол</td></tr>
</table>

		Брокероор дамжсан тохиолдолд 5% буюу 11,858,307.84 ам.дол
15	Дэнчин байршуулах банкны дансны мэдээлэл, валютын төрөл	**1.**Хүлээн авагч：MONGOLIAN STOCK EXCHANGE JSC Хүлээн авагчийн банк：XACBANK Свифт код: CAXBMNUB Дансны дугаар: MN 6400 3200 5005595301 Банкны хаяг：ULAANBAATAR XACBANK HQ BLDG, ULAANBAATAR-14200 2.Хүлээн авагч: MONGOLIAN STOCK EXCHANGE JSC Хүлээн авагчийн банк: GOLOMT BANK Свифт код：GLMTMNUB Дансны дугаар：MN 9700 1500 1105041063 Банкны хаяг：HEAD OFFICE OF GOLOMT BANK, D.SUKHBAATAR SQUARE 5, P.O.BOX 22, ULAANBAATAR 15160, MONGOLIA
16	Худалдан авагчид хүргэвэл зохих нэмэлт мэдээлэл	Худалдагч болон Худалдан авагч нь арилжаа явагдсан өдрөөс хойш ажлын 5 хоногийн дотор зэсийн баяжмалын худалдах, худалдан авах гэрээг байгуулна. Худалдан авагч нь төмөр замын ачилтын зааврыг ачилт явагдах сарын өмнөх сарын 15-ны өдрөөс өмнө бичгээр мэдэгдэнэ. Хөвөгч үнийн нөхцөлөөр арилжаалсан 1 (нэг) хуурай метр тонн баяжмалын эцсийн нэгж үнийг ачилт хийсэн сарын Лондонгийн Металлын Биржийн (LME) зэсийн сарын дундаж үнээр тооцсон баяжмалын үнэ дээр биржийн арилжааны үнийн өсөлтийг (хэлцлийн үнэ ба дуудах доод үнийн зөрүү) нэмж тооцно. Энэхүү эцсийн нэгж үнийг тооцохдоо арилжааны гэрээний 11 дүгээр зүйлийн дагуу тогтоосон жин, чийглэгийн эцсийн дүн, 12 дугаар зүйлийн дагуу баталгаажсан зэс болон дагалдах металлын химийн эцсийн агуулга, 2027 оны албан ёсны жишиг TC/RC-ийн залруулгыг бүрэн тусгаж эцэслэн тодорхойлно.
17	Биржийн мэдээллийн ажилтантай холбоо барих утасны дугаар	976-11-313315 (6113)

Энэхүү маягтад тусгасан мэдээллийн үнэн зөвийг худалдагч тал бүрэн хариуцна. Хэрэв Монгол, Англи, Хятад хэл дээрх зарын мэдээлэл хоорондоо зөрөх тохиолдолд Монгол хэл дээрх зарыг зөв гэж үзнэ.

БҮТЭЭГДЭХҮҮН НИЙЛҮҮЛЭХ ХУВААРЬ

Бүтээгдэхүүн нийлүүлэх хугацаа	Нийлүүлэлтийг дараах хуваарийн дагуу хийнэ 2027 оны 2-р сар 16,000 НМТ 2027 оны 3-р сар 16,000 НМТ 2027 оны 4-р сар 16,000 НМТ 2027 оны 5-р сар 16,000 НМТ 2027 оны 6-р сар 16,000 НМТ	
Төлбөр төлөх хугацаа	Худалдагч урьдчилгаа нэхэмжлэх бэлтгэн цахим шуудангаар Худалдан авагчид хүргүүлэх бөгөөд нэхэмжлэхийг гаргасан өдрөөс хойш Худалдан авагч банкны ажлын таван өдөрт багтаан төлбөрийг шилжүүлнэ	
Нийлүүлэх хэмжээ /тонн/	80,000 НМТ	72,480 ХМТ

ERDENET
Mining Corporation

Erdenet City, Mongolia Tel:(976 7573791); Fax: (976 70353002)

Pro-forma Invoice No:….. MSE-2027/01-Cu

Buyer:
Contract No: MSE-2027/01-Cu
Goods: Copper concentrates
Delivery: DAP Incoterms 2020 Mongolian-Chinese border at Erlian
Shipped to: Erlian railway station, China
Shipment period: February to June 2026

Net Wet Weight:				80,000.00	WMT
Moisture:				9.40	%
Net Dry Weight:				72,480.00	DMT
Assays, Provisional		Copper, (Cu):		22.35	%
		Silver, (Ag):		78.00	Grams/DMT
		Arsenic, (As):		0.30	%
Price: Average for 12 October to 10 November 2026			Cu:	14,415.59	USD/MT
			Ag:	54.557	USD/Oz
Contained Cu Price per DMT	(22.35 -0.5) * 14415.59 USD			=	3,149.81 USD
Contained Ag Price per DMT	78.000* 90 % / 31.1035 =			2.2570	Oz
	(54.557-0.35 USD) * 2.2570 Oz			=	122.35 USD
Deduct: T/C:				=	- USD
R/C:				=	- USD
As:	(0.30 - 0.30) % * 2.0 USD / 0.10 %			=	USD
Unit Price per DMT:				=	**3,272.16** USD
Auction unit price increase					
Executed unit price					**3,272.16**
Total Amount:	72,480.000 DMT * 3,272.16 USD			=	**237,166,156.80** USD
Collateral amount paid to MSE deductable:					**23,716,615.68** USD
Total Payment to EMC:					**213,449,541.12** USD

Signature

Signature

Signature

ГЭРЭЭ № MSE-2027/01-Cu
Эрдэнэт хот, Монгол

Энэхүү зэсийн баяжмал худалдах, худалдан авах гэрээг (цаашид “Гэрээ” гэх) 2026 оны 11-р сарын 20-ны өдөр

нэг талаас:

Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдан, үйл ажиллагаа явуулж байгаа **“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ**,
Бүртгэлийн хаяг: Монгол улс, Орхон аймаг, Баян-Өндөр сум, Найрамдал талбай 61027 (цаашид “Худалдагч” гэх)

нөгөө талаас:
……..(цаашид “Худалдан авагч” гэх) нар байгуулав.

ГЭРЭЭНИЙ ЗОРИЛГО:

Монголын Хөрөнгийн биржийн 2026 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн тоот хэлцлийн дагуу арилжаалагдсан “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-т хөвүүлэн баяжуулж үйлдвэрлэсэн зэсийн баяжмалыг (цаашид “баяжмал” гэх) дор дурдсан нөхцөлөөр Худалдагч худалдах, Худалдан авагч худалдан авахаар тохиролцов.

1. НЭР ТОМЬЁО

Энэхүү гэрээнд хэрэглэгдсэн дараах нэр томьёо, тодорхойлолтууд нь доор дурдсан утгатай байна. Үүнд:
- “Тонн” болон “Метр Тонн” гэсэн нэр томьёо нь 1000 кг эсвэл 2204.62 фунттай тэнцүү байна;
- “ХМТ” нь хуурай метр тонн, “НМТ” нь нойтон метр тонн гэсэн утгатай байна;

CONTRACT № MSE-2027/01-Cu
Erdenet, Mongolia

This Contract on Sales and Purchase of Copper Concentrates (hereinafter the “Contract”) is made on this day, 20th of November, 2026

by and between:

Erdenet Mining Corporation SOE, a legal entity organised and operating under the laws of Mongolia with its registered address at: 61027 Nairamdal Square, Bayan-Undur soum, Orkhon aimag, Mongolia (hereinafter the “Seller”)

And
…..... (hereinafter the “Buyer”).

SUBJECT OF THE CONTRACT:

The Buyer agrees to buy, and the Seller agrees to sell copper flotation concentrates (hereafter referred to as “the Concentrates”) produced by Erdenet Mining Corporation SOE, traded under the Agreement No ..... of the Mongolian Stock Exchange on 20 November 2026, on the following terms and conditions:

1. DEFINITIONS:

The following terms and expressions, used in this Contract, shall have the meanings set out below:

- The term “Tonne” and “Metric Ton” each means 2204.62 Pounds or 1000 kilograms;

- The terms “DMT” and “WMT” mean Dry Metric Ton and Wet Metric Ton, respectively;

- “Нэгж” гэсэн нэр томьёо нь хуурай метр тонны нэг хувь гэсэн утгатай байна;
- “Жил” гэдэг нь тухайн жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөр эхэлж 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусах дараалсан 12 сарын хугацааг хэлнэ;
- “Унци” буюу “oz” гэдэг нь 31.1035 граммтай тэнцүү хэмжигдэхүүнийг хэлнэ;
- “PPM” болон “гр/тонн” гэдэг нь саяны нэг буюу 1 метр тоннд 1 граммтай тэнцүү байна;
- “Фунт” буюу “lb” гэдэг нь 453.593 граммтай тэнцүү хэмжигдэхүүнийг хэлнэ;
- “Доллар” болон “цент” гэдэг нь Америкийн Нэгдсэн Улсын мөнгөн тэмдэгт болох доллар болон центээр ($ ба ¢) илэрхийлэгдэнэ.

- The term “Unit” means 1% of the net dry weight;

- The term “Year” means a period of 12 consecutive months commencing 1st January and ending 31st December of the concerned year;

- The term “Ounce” or “oz” means a troy ounce or equal to 31.1035 grams;
- The term “PPM” or “g/MT” means part per million or 1 gram per Metric Ton;
- The term “Pound” or “lb” means one pound equal to 453.593 grams;
- “Dollar” and “cents” ($ and ¢) are references to the currency of the United States of America.

2. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА:

2.1. Энэхүү Гэрээ болон түүний Нэмэлтүүд нь талууд гарын үсэг зурж, тамга дарагдсан өдрөөс хүчин төгөлдөр болох бөгөөд 2027 оны 8-р сарын 31-ний өдрөөр дуусгавар болно.

2. DURATION:

2.1. This Contract and all Amendments thereto shall enter into force from the date of signing and stamping by both Parties and shall remain in force until 31 August 2027.

3. ТОО ХЭМЖЭЭ:

3.1. Энэхүү гэрээний дагуу нийлүүлэх баяжмалын нийт тоо хэмжээ нь 80,000 НМТ (наян мянга) байна.

3.2. Нийлүүлэлтийг 2027 оны 2 дугаар сараас 2027 оны 6 дугаар сарыг дуустал сар бүр 16,000 НМТ-оор (сар бүр 16 багц) дараах хуваарийн дагуу гүйцэтгэнэ:

- 2027 оны 02 дугаар сард: 16,000 НМТ
- 2027 оны 03 дугаар сард: 16,000 НМТ
- 2027 оны 04 дүгээр сард: 16,000 НМТ
- 2027 оны 05 дугаар сард: 16,000 НМТ
- 2027 оны 06 дугаар сард: 16,000 НМТ

3. QUANTITY:

3.1. The total quantity of the Concentrates to be delivered under this Contract shall be 80,000 WMT (eighty thousand).

3.2. The delivery shall be performed from February 2027 through June 2027 at 16,000 WMT per month (16 lots per month) in accordance with the following monthly shipment schedule:

- February 2027: 16,000 WMT
- March 2027: 16,000 WMT
- April 2027: 16,000 WMT
- May 2027: 16,000 WMT
- June 2027: 16,000 WMT

3.3. Худалдагч болон Худалдан авагч нь Худалдагчийн үйлдвэрлэлийн төлөвлөгөөнд гэнэтийн өөрчлөлт гарснаас бусад тохиолдолд

3.3. The Seller and the Buyer shall strictly adhere to the shipment schedule set forth in Clause 3.2 hereof,

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ

Buyer’s name

энэхүү гэрээний 3.2-т дурдсан ачилтын хуваарийг чанд мөрдөнө.

Худалдагчийн сонголтоор ачилтын хуваарьт өөрчлөлт орсон тохиолдолд “ачилт хийгдсэн сар”-ыг төмөр замын падаан дээр бичигдсэн огноогоор баталгаажсан тухайн ачилтын ихэнх хэсэг нь ачигдсан хуанлийн сараар тодорхойлно.

except in cases of unforeseen changes in the Seller's production plan.

In the event that the shipment schedule is revised at the Seller’s option, the “month of shipment” shall be defined as the calendar month in which the majority of the respective shipment is shipped, as evidenced by the railway bill dates.

4. ЧАНАР:

4.1. Энэхүү Гэрээний дагуу нийлүүлэх зэсийн баяжмал “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-т хөвүүлэн баяжуулах аргаар Монгол улсад үйлдвэрлэсэн байх бөгөөд чанар нь дараах химийн бүтэцтэй байна:

Химийн элемент	Агуулга
Cu	22.35%
Mo	<0.15%
Fe	<30%
Zn	<0.7%
Pb	<1.4%
As	<0.3%
S	<37%
Ag	78g/t
Au	<0.3 g/t
Al	<2.0%
Чийглэг	9.4%

4.2. Бүтээгдэхүүн нь хайлуулах явцад хор учруулах аливаа хорт бодис болон ямар нэгэн хатуу биет агуулаагүй байна.

4.3. Баяжмалд ямар нэгэн хортой бодис зөвшөөрөгдөх хэмжээнээс илүү хэмжээнд илэрсэн тохиолдолд талууд харилцан зөвшилцөж, асуудлыг шийднэ. Худалдан авагч баяжмалыг авахаас татгалзах эрхгүй.

4. QUALITY AND DESCRIPTION:

4.1. The Concentrates to be delivered under this Contract shall be a flotation copper concentrate produced by the Erdenet Mining Corporation SOE in Mongolia with the following chemical composition:

Characteristic	Content
Cu	22.35%
Mo	<0.15%
Fe	<30%
Zn	<0.7%
Pb	<1.4%
As	<0.3%
S	<37%
Ag	78g/t
Au	< 0.3 g/t
Al	<2.0%
W moisture	9.4%

4.2. The concentrate shall be free of impurities deleterious to the smelting process and extraneous solids.

4.3. In case of detection of any other impurities exceeding the allowed limits, both Parties shall discuss and resolve the matter. However, the Buyer shall have no right to refuse the delivery of the concentrates.

5. НИЙЛҮҮЛЭХ НӨХЦӨЛ

5. DELIVERY:

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ

Buyer’s name

5.1. Баяжмалыг Монгол-Хятадын хил DAP Эрээн (Инкотермс 2020, түүнд орсон нэмэлт өөрчлөлт) нөхцөлөөр төмөр замын вагоноор нийлүүлнэ.

5.2. Баяжмал нь буцаан олгогдохгүй нөхцөлтэй тус бүр 2.5-3.5 метр тонны багтаамжтай том уутанд савлагдан ачигдана.

5.1. The Concentrate shall be delivered by railway cars on DAP Erlian, Mongolian/Chinese border (Incoterms 2020 and any amendments thereto).

5.2. The Concentrate shall be delivered in non-returnable big bags of 2.5-3.5 metric tons each.

6. АЧИЛТ:

6.1. Худалдагч нь сар бүрийн хуваарьт ачигдах баяжмалыг энэхүү гэрээний 8.2-р заалтын дагуу урьдчилгаа төлбөрийг Худалдан авагч төлснөөс хойш 7 ажлын өдрийн дотор багтаан ачилтыг эхлүүлнэ.

6.2. Худалдан авагч нь хайлуулах үйлдвэр баяжмалыг хуваарийн дагуу хүлээн авахад бэлэн байгааг Худалдагчид мэдэгдэж төмөр замын ачилтын зааврыг сар бүрийн ачилт явагдах сарын өмнөх сарын 15-ны өдрөөс өмнө бичгээр мэдэгдэнэ.

6.3. Худалдан авагч заасан хугацаанд ачилтын зааврыг ирүүлээгүй тохиолдолд Худалдагч тухайн сарын ачилтыг цуцлах эрхтэй.

6.4. Ачилт дууссанаас хойш ажлын 5 өдөр дотор Худалдагч дараах баримт бичгүүдийн хуулбарыг Худалдан авагчид цахим шуудангаар илгээнэ:

- Вагон тус бүрийн дугаар, жин зэргийг багтаасан ачилтын мэдээ;
-Төмөр замын падаан;
- Ачигдсан баяжмалын жин, чанарын гэрчилгээ.

6. SHIPMENT:

6.1. The Seller shall commence the shipment of the monthly scheduled concentrates not later than 7 working days from the date of the Buyer's provisional payment, made in accordance with Clause 8.2 of this Contract.

6.2. The Buyer shall present and inform the Seller in writing of the Railway Bill Instructions and the readiness of receipt of the concentrate by the receiving smelter within the first 15 days of the month prior to the scheduled month of shipment.

6.3. In case the Buyer fails to inform the Railway Bill Instructions within the stated period, the Seller has the right to cancel the shipment for that month.

6.4. Within 5 working days following the date of shipment, the Seller shall forward to the Buyer the copy of the following documents by email:

- Shipping details, including r/w bill numbers and weight of each railway car;
-Railway bills;
- Quality and quantity certificate for the dispatched Concentrates.

7. БАЯЖМАЛЫН ҮНЭ

7.1. Энэхүү гэрээний дагуу нийлүүлэх зэсийн баяжмалыг хөвөгч үнийн нөхцөлөөр арилжаална.

7.2. Зэсийн баяжмалын дуудах доод үнэ:
Монголын Хөрөнгийн биржийн 2026 оны 11 дугаар сарын 20-ны өдрийн.....тоот

7. CONCENTRATE PRICE:

7.1. The copper concentrate to be delivered under this Contract shall be traded under floating price terms.

7.2. The call price of the copper concentrate:
The call price per dry metric ton /DMT/ of copper concentrates traded under Agreement No.…. of the

"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ

Buyer's name

хэлцлийн дагуу худалдсан, нэг хуурай метр тонн /ХМТ/ зэсийн баяжмалын дуудах доод үнэ 3,272.16 ам.доллар байна.

Биржийн арилжааны дуудах доод үнийг арилжааны захиалга өгөх өдрийн өмнөх хуанлийн 7 хоног болон 30 хоногийн Лондонгийн Металлын Биржийн дундаж үнийн аль өндрийг үндэслэн тогтооно.

7.3. Урьдчилгаа төлбөрийн нэгж үнэ:

Сар бүрийн ачилтын 1 (нэг) хуурай метр тонн зэсийн баяжмалын урьдчилгаа төлбөрийн нэгж үнэ нь Монголын Хөрөнгийн Биржийн арилжаанаас тогтоогдсон хэлцлийн үнэ байна.

7.4. Эцсийн төлбөрийн нэгж үнэ:

Хөвөгч үнийн нөхцөлөөр арилжаалсан 1 (нэг) хуурай метр тонн баяжмалын эцсийн нэгж үнийг ачилт хийсэн сарын Лондонгийн Металлын Биржийн (LME) зэсийн сарын дундаж үнэ болон Лондонгийн Үнэт Металлын Зах Зээлийн Холбооны (LBMA) мөнгөний сарын дундаж үнийг үндэслэн тооцсон баяжмалын үнэ дээр биржийн арилжааны үнийн өсөлтийг нэмж тооцно.

Энэхүү эцсийн нэгж үнийг тооцохдоо 11 дүгээр зүйлийн дагуу тогтоосон жин, чийглэгийн эцсийн дүн, 12 дугаар зүйлийн дагуу баталгаажсан зэс болон дагалдах металлын химийн эцсийн агуулга, 2027 оны албан ёсны жишиг TC/RC-ийн залруулгыг бүрэн тусгаж эцэслэн тодорхойлно.

7.5. Зэсийн баяжмалын үнийг дараах нөхцөлөөр тооцно. Үүнд:

- Төлөгдөх металлын хасалт: Зэсийн дундаж агуулгаас 0.5 нэгжийг хасаж тооцно.
- Мөнгөний агуулгын 90%-д төлбөр тооцно;
-Мөнгөний цэвэршүүлэх зардал: 1 унци төлөгдөх мөнгө тутмаас 0.35 ам.доллар хасаж тооцно;
- Хүнцлийн торгууль: Арсеникийн агуулга

Mongolian Stock Exchange dated 20 November 2026 shall be USD 3,272.16.

The Call Price of concentrate at the exchange auction is calculated based on the higher of the 7-day or 30-day LME cash settlement average metal prices prior to the trading order submission date.

7.3. Provisional Unit Price:

The provisional unit price per 1 (one) dry metric ton of copper concentrate for each monthly shipment shall be the transaction price determined at the Mongolian Stock Exchange auction.

7.4. Final Unit Settlement Price:

The final unit price per 1 (one) dry metric ton of concentrate traded under floating price terms shall be calculated by adding the auction price increase achieved during exchange trading to the concentrate price determined based on the London Metal Exchange (LME) monthly average cash settlement copper price and the London Bullion Market Association (LBMA) monthly average silver price for the actual month of shipment.

Such final unit price shall be definitively calculated by incorporating the final weight and moisture determined under Clause 11, the certified actual chemical assays of copper and payable metals under Clause 12, and the adjustment of the official 2027 benchmark TC/RC.

7.5. The price for copper concentrate shall be calculated based on the following terms and conditions:

- Metal Deduction: 0.5 units deduction from copper content;
- Payment for 90% of silver content;
- Silver Refining Charge: Deduct US$0.35 per troy ounce of payable silver;

0.30%-иас дээш гарсан тохиолдолд илүү гарсан 0.10% тутамд 2.00 ам.доллар/ХМТ хасаж тооцно.

7.6. Хайлуулах, цэвэршүүлэх зардал:

Энэхүү гэрээний дагуу нийлүүлэх зэсийн баяжмалын хайлуулах, цэвэршүүлэх зардлыг CRU судалгааны байгууллагын Copper Raw Materials сэтгүүлээс зарлагдах 2027 оны урт хугацааны жилийн гэрээний жишиг үзүүлэлтийг үндэслэнэ.

2027 оны урт хугацаат гэрээний бэнчмарк нөхцөл албан ёсоор зарлагдаагүй байгаа тул 2026 оны урт хугацаат гэрээний хайлуулах, цэвэршүүлэх зардлын жишиг үзүүлэлтийг урьдчилсан нөхцөл болгон хэрэглэнэ.

2027 оны урт хугацаат гэрээний хайлуулах, цэвэршүүлэх зардлын албан ёсны жишиг нөхцөл нийтлэгдсэний дараа гэрээний эцсийн үнийг 2027 оны жишиг нөхцөлөөр залруулан тооцно.

CRU байгууллагаас тухайн оны хайлуулах, цэвэршүүлэх зардлын албан ёсны жишиг нөхцөлийг зарлаагүй тохиолдолд Талууд хэлэлцэн тохиролцож жишиг нөхцөлийг тогтоох бөгөөд уг тохиролцсон нөхцөлийг 7.4-т заасны дагуу гэрээний эцсийн нэгж үнийг тооцоход мөрдөнө.

- Arsenic Penalty: In case arsenic content exceeds 0.30%, a deduction of US$2.00 per DMT applies for each 0.10% exceeding 0.30%.

7.6. Treatment and Refining Charges

The treatment and refining charges for the copper concentrate to be delivered under this contract shall be based on the annual long-term contract benchmark for 2027 published in CRU Group Copper Raw Materials publication.

As the definitive long-term benchmark terms for 2027 have not yet been established, the long-term annual contract TC/RC benchmark for 2026 shall be applied as a provisional term.

Upon official publication of the definitive 2027 annual benchmark for treatment and refining charge, the final contract settlement price shall be adjusted based on the 2027 benchmark terms.

In the event that CRU Group does not publish the official annual TC/RC benchmark for the applicable year, the Parties shall negotiate and agree upon the benchmark terms, and such agreed terms shall apply to calculate the final contract unit price pursuant to Clause 7.4.

8. ТӨЛБӨР:

8.1. Бүх нэхэмжлэх болон авлагын мэдэгдэл зэрэг нь ам. доллар, центээр байх бөгөөд бүх төлбөрийг АНУ-ын доллар, центээр нэхэмжлэлийн дагуу шилжүүлнэ.

8.2. Урьдчилгаа төлбөр:

Худалдагч нь энхүү гэрээний 7.3-т заасан нэгж үнэ болон тухайн сард нийлүүлэх тоо хэмжээнд (ХМТ) үндэслэн тооцсон урьдчилгаа төлбөрөөс Худалдан авагчийн Монголын Хөрөнгийн Биржид байршуулсан тухайн нийлүүлэх бүтээгдэхүүний тоо

8. PAYMENT:

8.1. All invoices or credit notes shall be in Dollars and Cents, and all payments shall be made by telegraphic transfer in US Dollars and Cents, according to the invoices.

8.2. Provisional Payment:

The Seller shall issue the provisional invoice based on the unit price specified in Clause 7.3 and the scheduled monthly delivery quantity (DMT), less the portion of the collateral deposit placed by the Buyer with the Mongolian Stock Exchange attributable to

хэмжээнд хамаарах дэнчингийн төлбөрийг суутган урьдчилсан нэхэмжлэхийг бэлтгэнэ.
Худалдагч нэхэмжлэхийг гаргасан өдрөөс хойш Худалдан авагч банкны ажлын таван өдөрт багтаан төлбөрийг шилжүүлнэ. Төлбөрийг заасан хугацаанд шилжүүлээгүй тохиолдолд Худалдагч тухайн сарын ачилтыг цуцлах эрхтэй.
8.3. Эцсийн төлбөр:
а) Худалдагч нь энэхүү гэрээний 7.4 дэх заалтын дагуу тодорхойлсон эцсийн нэгж үнийг үндэслэн тооцсон эцсийн төлбөрөөс Худалдан авагчийн урьдчилгаа төлбөр болон тухайн нийлүүлсэн бүтээгдэхүүний тоо хэмжээнд хамаарах дэнчингийн төлбөрийг суутган эцсийн нэхэмжлэхийг бэлтгэнэ.
b) Эцсийн нэхэмжлэх бэлтгэгдсэнээс хойш банкны ажлын 5 өдөрт багтаан Худалдагч эсвэл Худалдан авагч эцсийн зөрүү төлбөрийг шилжүүлнэ.

the quantity of Concentrates to be delivered during the relevant month.

The Buyer shall transfer the provisional payment within five (5) banking days from the date of the Seller's provisional invoice.
In case of non-payment within the period, the Seller has the right to cancel the shipment for that month.

8.3. Final Payment:
a) The Seller shall issue the final invoice based on the final settlement amount calculated in accordance with the final unit price defined in Clause 7.4 hereof, net of the Buyer's provisional payment and the portion of the collateral deposit attributable to the delivered product quantity.
b) Buyer or Seller shall make the final balance payment according to the final invoice within five (5) banking days after the final invoice date.

9. ӨМЧЛӨХ ЭРХ БА ЭРСДЭЛ:

9.1. Баяжмалыг өмчлөх эрх нь энэхүү гэрээний 8-р зүйлийн дагуу тухайн ачилтын урьдчилгаа төлбөрийг Худалдагч хүлээн авснаар Худалдан авагчид шилжинэ.
9.2. Ачааны вагон Монгол/Хятадын хилийн зурвасыг нэвтэрснээр эрсдэл Худалдан авагчид шилжинэ.

9. TITLE AND RISK:

9.1. The title to the Concentrate shall pass from the Seller to the Buyer upon provisional payment being received by the Seller in accordance with Clause 8 hereof.
9.2. The risk shall pass to the Buyer at the time when the rail cars with the Concentrates cross the Mongolian/Chinese border.

10. ДААТГАЛ:

10.1. Гэрээний 5-р зүйлд дурдсан нийлүүлэх цэг хүртэлх аливаа даатгалын зардлыг Худалдагч хариуцна.

10.2. Нийлүүлэх цэгээс цааш гарсан бүх эрсдэлтэй холбоотой аливаа даатгалын зардлыг Худалдан авагч хариуцна.

10. INSURANCE:

10.1. The insurance up to the point of delivery in accordance with Clause 5 of this Contract shall be the responsibility of the Seller.

10.2. The insurance after the point of delivery shall be the responsibility of the Buyer against all risks.

"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ

Buyer's name

11. ЖИГНЭЛТ, ДЭЭЖ АВАЛТ, ЧИЙГЛЭГ ТОДОРХОЙЛОЛТ:

11.1. Баяжмалын жигнэлт, дээж авалт, чийглэг тодорхойлох ажлыг Монголын Хөрөнгийн биржид бүртгэгдсэн, Лондонгийн Металлын Биржийн гишүүнчлэлтэй, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хөндлөнгийн хяналтын байгууллага Худалдагчийн агуулахад баяжмал ачигдах үед олон улсын стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.

11.2. Баяжмалын жин, чийглэгийг тодорхойлохдоо нэг лот (багц) тутмаас дээж авч олон улсын стандартын дагуу хийж гүйцэтгэнэ. Сар бүрийн ачилтын жин, чанарыг тухайн ачилтыг бүрдүүлж байгаа 16 лотны үр дүнг нэгтгэн тооцож тодорхойлно.

11.3. Эцсийн хуурай жинг Худалдагчийн агуулахад хөндлөнгийн хяналтын байгууллагын хяналтын дор тодорхойлох бөгөөд энэхүү жинг хоёр тал хүлээн зөвшөөрөх ба эцсийн жин болно.

11.4. Худалдагчийн агуулахад жин, чийглэг тодорхойлох ажилд Худалдан авагч өөрийн зардлаар оролцож болно.

11.5. Худалдагчийн агуулахад хөндлөнгийн хяналтын байгууллагын жин, чийглэг тодорхойлж дээж авсан үйлчилгээний төлбөрийг Худалдагч хариуцан төлнө.

12. ХИМИЙН ШИНЖИЛГЭЭ:

12.1. Монголын Хөрөнгийн биржид бүртгэгдсэн, Лондонгийн Металлын Биржийн гишүүнчлэлтэй, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хөндлөнгийн хяналтын байгууллага Худалдагчийн агуулахад баяжмал ачигдах үед лот тус бүрээс химийн агуулга тодорхойлох дээжийг олон улсын стандартын дагуу бэлтгэнэ.

11. WEIGHING, SAMPLING AND DETERMINATION OF MOISTURE:

11.1. The weighing, sampling and moisture determination shall be made during the loading process at the Seller's warehouse according to established international practice under the control of an internationally recognized independent controlling organization accredited by the Mongolian Stock Exchange and member of the London Metal Exchange.

11.2. The weighing and determination of moisture shall be carried out per lot according to established international standards. The monthly shipment weight and quality shall be determined by consolidating the results of the 16 lots comprising that shipment.

11.3. The final dry weight of the Concentrates determined at the Seller's warehouse by the controlling organization shall be the final weight for settlement between the Parties.

11.4. The Buyer's representative may participate in such weighing and moisture determination at the Seller's warehouse at the Buyer's expense.

11.5. The cost of the controlling organization for weighing and moisture determination at the Seller's warehouse shall be wholly paid by the Seller.

12. ASSAYS:

12.1. An internationally recognized independent controlling organization accredited by the Mongolian Stock Exchange and a member of the LME shall prepare samples for chemical analysis in lots during the loading process at Seller's warehouse according to established international practice.

12.2. Лот тутмаас авсан дээж нь 4 тэнцүү хэсэгт хуваагдан зэс, мөнгө, хүнцлийн агуулгыг тодорхойлох зориулалттайгаар хийгдэх ба 2 дээжийг хөндлөнгийн хяналтын байгууллагын шинжилгээнд, 2 дээжийг болзошгүй маргаан таслах зориулалтаар хадгална.

12.2. The sample for each lot shall be divided into 4 (four) equal portions for copper, silver and arsenic assays: 2 sets for controlling organization chemical analysis and 2 sets retained for possible umpire analysis.

12.3. Хөндлөнгийн хяналтын байгууллага нь зэсийн баяжмалын химийн шинжилгээг хийж, зэс болон хүнцлийн агуулгыг аравтын 2 оронтойгоор нэг ХМТ-д хувиар, цагаан мөнгөний агуулгыг нэг ХМТ-д граммаар бүхэл тоогоор илэрхийлнэ.

12.3. The controlling organization shall conduct chemical analysis: copper and arsenic stated in % of DMT (2 decimal places), and silver in grams per DMT (no decimals).

12.4. Хөндлөнгийн хяналтын байгууллагын тодорхойлсон энэхүү шинжилгээний үр дүнг хоёр тал хүлээн зөвшөөрч эцсийн тооцоонд хэрэглэнэ.

12.4. These assay results determined by the controlling organization shall be accepted by and applied for final settlement between the Parties.

12.5. Хөндлөнгийн хяналтын байгууллагын химийн шинжилгээ хийсэн үйлчилгээний төлбөрийг Талууд тэнцүү 50/50 хувиар хуваан төлнө.

12.5. The cost of the independent controlling organization for chemical analysis shall be borne equally by the Parties on a 50:50 percent basis.

13. ГЭРЭЭГ ДҮГНЭХ:

13. FINALIZATION OF THE CONTRACT:

13.1. Энэхүү гэрээний 8.3-р заалтын дагуу нийт 80,000 НМТ баяжмалын ачилтуудын эцсийн нэхэмжлэхийн төлбөр бүрэн төлөгдөж дууссанаас хойш ажлын 15 хоногийн дотор талууд гэрээ хаах тухай протоколд гарын үсэг зурж гэрээг дүгнэнэ**.**

13.1. The Parties shall sign a Protocol to finalize the Contract within 15 working days from the date of final payment under the Final Invoices for all shipments totaling 80,000 WMT in accordance with Clause 8.3 of this Contract.

14. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ:

14. FORCE MAJEURE:

14.1. Энэхүү гэрээнд “Давагдашгүй хүчин зүйл” гэж Худалдагч болон Худалдан авагч нь үүргээ гүйцэтгэх боломжгүй болгосон нөхцөл байдал үүсгэсэн Талуудаас үл хамаарах байгалийн гамшиг, дайн, ажил хаялт, Засгийн газрын хориг шийдвэр, төмөр замын тасалдал зэргийг хэлнэ.

14.1. Force Majeure shall mean events beyond the control of a Party preventing performance under the Contract, including acts of God, war, strikes, government restrictions, or railway blockage.

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ	Buyer’s name

14.2. Өртсөн тал 10 хоногийн дотор нөгөө талдаа бичгээр мэдэгдэж, Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын гэрчилгээг хавсаргана.

14.3. Хүчин зүйл 3 сараас дээш үргэлжилбэл өртөөгүй тал нийлүүлэгдэх байсан тоо хэмжээг цуцлах эрхтэй. 12 сараас хэтэрвэл гэрээг цуцалж болно.

14.2. The affected Party shall give written notice within 10 working days, evidenced by a Chamber of Commerce certificate.

14.3. If the duration exceeds 3 months, the unaffected Party may cancel the affected tonnage. If it exceeds 12 months, either Party may terminate this Contract.

15. ТАТВАР ХУРААМЖ:

15.1. Монгол улсын нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа болон цаашид үүсэх бүх гаалийн болон бусад татварыг Худалдагч хариуцна.

15.2. Монгол улсын нутаг дэвсгэрээс гадна талд үүсэх аливаа татвар, хураамжийг Худалдан авагч хариуцна.

15. TARIFFS AND DUTIES:

15.1. All tariffs, taxes and duties on the territory of Mongolia shall be borne by the Seller.

15.2. All tariffs, taxes and duties outside of Mongolia shall be borne by the Buyer.

16. ЛИЦЕНЗ:

16.1. Шаардлагатай экспортын зөвшөөрлийг Худалдагч, импортын зөвшөөрлийг Худалдан авагч тус тус хариуцан хугацаанд нь гаргана.

16. LICENCES:

16.1. The Seller guarantees timely issuance of export licenses, and the Buyer guarantees timely issuance of import licenses, if required.

17. ГЭРЭЭНИЙ ЭРХ ШИЛЖҮҮЛЭХ:

17.1. Талууд энэхүү гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй.

17. SUCCESSORS AND ASSIGNS:

17.1. Neither Party shall assign this Contract to any Third Party.

18. АРБИТР БА ХОЛБОГДОХ ХУУЛЬ:

18.1. Аливаа маргааныг Монголын Үндэсний Худалдаа, Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитрын журмаар, Улаанбаатар хотод, монгол хэл дээр шийдвэрлэнэ.

18.2. Энэхүү гэрээнд Монгол Улсын хууль тогтоомж хэрэглэгдэнэ.

18. ARBITRATION AND GOVERNING LAW:

18.1. Any dispute arising out of this Contract shall be finally settled by arbitration at the Mongolian International Arbitration Court at MNCCI in Ulaanbaatar, in the Mongolian language. шийдвэрлэнэ.

18.2. The laws of Mongolia shall govern this Contract.

19. МЭДЭГДЭЛ, НУУЦЛАЛ, БУСАД НӨХЦӨЛ:

19. NOTICES, CONFIDENTIALITY AND OTHER TERMS:

_____	_____
“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ	Buyer’s name

19.1. Бүх мэдэгдлийг гэрээнд заасан албан ёсны хаяг, цахим шуудангаар хүргүүлнэ.

19.2. Талууд гэрээний нөхцөл, мэдээллийн нууцыг чандлан хадгална.

19.3. Энэхүү гэрээний үндсэн эхийг Монгол-Англи хэл дээр тус бүр 2 хувь үйлдсэн бөгөөд зөрүүтэй тохиолдолд монгол хэл дээрх эхийг баримтална.

19.1. All notices shall be delivered in writing to the official addresses and emails specified in the Contract.

19.2. Neither Party shall disclose confidential terms to third parties without prior written consent.

19.3. This Contract is made in Mongolian and English in 2 original copies; in case of discrepancy, the Mongolian version shall prevail.

Signed by:

For and on behalf of **Erdenet Mining Corporation SOE:**

“**Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ**-ын нэрийн өмнөөс:

G. Yondon _____
General Director
Date: …. …… …….

For and on behalf of**:**

…..... компанийн нэрийн өмнөөс:

_____

Date: …. …… …….

_____
“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ

_____
Buyer’s name